

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар “Аймгийн эрдэс баялгийн зөвлөлийн ажиллах журам батлах тухай 2017 оны 46 дугаар тогтоолын хэрэгжилт”, “Дугуй хөрөө ажиллуулах журам батлах тухай 2012 оны 101 дүгээр тогтоолын хэрэгжилт”, “Иргэдийн аялал жуучлалын журам батлах тухай 2014 оны 37 дугаар тогтоолын хэрэгжилт”, “ХАА-н зориулалттай техник тоног төхөөрөмжийг ашиглуулах журам батлах тухай 2014 оны 42 дугаар тогтоолын хэрэгжилт”, “Спортын өндөр амжилт гаргасан тамирчин дасгалжуулагч, уяач, багийг урамшуулах журамд өөрчлөлт оруулах тухай”, “Бат-Өлзий суманд үйл ажиллагаа явуулж буй ойн нөхөрлөл, аж ахуйн нэгжид хийсэн шалгалтын дүнд тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилт”, “Хүүхдэд ээлтэй аймаг хөтөлбөрийн хэрэгжилт”, “Нэг иргэн нэг ажлын байр хөтөлбөрийн хэрэгжилт”, “Үхэр сүрэг хөтөлбөр батлах тухай” зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Хангайн бүсийн аймгуудын “ИТХ-ын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх нь” туршлага солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх уулзалт, хэлэлцүүлгийг Булган аймгийн ИТХ-аас УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран зохион байгуулж тус уулзалт, хэлэлцүүлэгт Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, Ажлын албаны 100 гаруй төлөөлөл оролцлоо.

Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарт сургалт зохион байгуулав. Тус сургалтаар Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, Орон нутгийн төсвийн зохицуулалт, Цахим орчинд мэдээлэл түгээх, Стрессийн удирдлага, Эгэх хариуцлага, Хувь хүний харилцаа, хандлага зэрэг олон сэдвээр зохион байгуулж, “Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө” аргачлалд суралцан, мөн зарим сумдын ИТХ-ын байгууллага хэрэгжүүлж буй тэргүүн туршлагаасаа хуваалцаж, санал солилцлоо.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2018, 2019 оны зарцуулалтад төсвийн хяналтын сонсголыг аймгийн ИТХ-ын Ажлын албанаас зохион байгуулав. Сонсголд ажиглагчаар 25, оролцогчоор 3 иргэн, аймгийн ИТХ-ын Төсөв санхүүгийн бодлого зохицуулалтын хорооны Төлөөлөгчид, мөн аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Мэргэжлийн хяналтын газрын холбогдох албан тушаалтнууд оролцов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Арвайхээр суманд баригдаж буй Хаус хороололын дэд бүтцийн асуудлыг шуурхай шийдэрлэхээр аймгийн Онцгой комисс хуваарийн дагуу ажиллаж, дулаан, цахилгааны шугам сүлжээг холбох, цэвэр, бохир усны асуудлыг шийдвэрлэх, орчны тохижилтыг шуурхай хийж гүйцэтгэхээр ажиллаж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ оныг “Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил” болгон, төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалтыг аймаг, сумын түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байна. Арвайхээр суманд 12.6 км хатуу хучилттай авто зам, 14 байгууллагын гадна зогсоол талбайг

шинээр барьж, сумдад авто замын шинэчлэлт, засварлалт, гүүрэн байгууламжийг шинээр барьж ашиглалтад оруулав.

Бүрд, Тарагт, Гучин-Ус суманд Соёлын төв, Баян-Өндөр суманд спорт заал, Сантад хүүхдийн цэцэрлэг, Өлзийт суманд 320 хүүхдийн сургууль, Баянгол суманд Соёлын төв, Төгрөг суманд Спорт заал, Богд суманд 320 хүүхдийн сургууль, Баруунбаян-Улаанд сургуулийн 100 хүүхдийн дотуур байр, Хайрхандулаан суманд 240 хүүхдийн сургууль баригдаж байна.

Мөн Тарагтад сумын ЗДТГазар, спорт заал, Уянга суманд Соёлын төв, Жаргалант багт 120 хүүхдийн сургууль, Бат-Өлзий суманд Орхон голын гүүр, Цагаанголын гүүр, Хужиртад бетонон гүүр, авто зам, хөл бөмбөгийн талбай, Хархорин сумын 320 хүүхдийн сургууль, 75 хүүхдийн цэцэрлэг, шашны сургуулийн 100 хүүхдийн дотуур байр баригдаж байна.

Аймгийн Цагдаагийн газрын байрыг шинээр ашиглалтад оруулсан бөгөөд Тус барилга нь Арвайхээр хотын шинэ суурьшлын бүсэд 3 давхар, 1750 м² хэмжээтэй юм.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/297 дугаар тушаалын дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж, ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлагын газрын Мэргэжлийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга, дэд хурандаа Л.Тамираар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн Бат-Өлзий, Баян-Өндөр, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Сант, Уянга, Хархорин, Хужирт, Есөнзүйл зэрэг сумдад бэлэн байдлыг үзлэгийг шалгаж, гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, хүч хэрэгслийн бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадварыг дээшлүүлэх талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны чиглэлтэй танилцаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан юм.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгон зарласантай холбогдуулан аймгийн Татварын хэлтэс "Дуудлагаар татварын үйлчилгээ үзүүлэх програм"-ыг нэвтрүүлээд байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга П.Зоригтбаатараар ахлуулсан зөвлөн туслах ажлын хэсэг аймгийн Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, харъяа газар, хэлтэс, сумдын Засаг даргын Тамгын газар зэрэг байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, стратеги төлөвлөгөө, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах талаар сургалт зохион байгуулав.

"Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилт жил"-ийн ажлын хүрээнд Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор намрын бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулж, нийтийн эзэмшлийн талбай, амьдардаг орчиндоо мод бут тарих, ногоон байгууламжид үзлэг тооллого хийх, тарьсан мод бутыг өвөлжүүлэх бэлтгэлийг хангах, намрын цэнэг усалгаа хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ. Аймгийн хэмжээнд нийт 102 аж ахуйн нэгж, байгууллага, 1890 иргэн оролцож, 800 ширхэг мод, 1900 ширхэг бут сөөг буюу нийт 2700 ширхэг мод бут тарьсан байна.

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгийн бүрэлдэхүүн аймгийн Засаг даргын Тамгын газар, холбогдох төрийн байгууллагуудад хяналт-шинжилгээ хийж, арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллав. Аймгийн Төрийн үйлчилгээний төвийн иргэний танхимд "Иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөг"-ийг 170 гаруй иргэд, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулсан "Олон нийтийн хяналт ба шударга ёс" сэдэвт уулзалтыг зохион байгуулав. Мөн тус аймгийн ХАСХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудын сургалтад сумдын

Тамгын газрын дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, хэлтэс, газар, албадын ХАСХОМ хариуцсан нийт 56 эрх бүхий албан тушаалтныг, ХОМэдүүлэг гаргах 200 гаруй төрийн албан хаагчдыг идэвхитэй хамруулан, сургалт, хэлэлцүүлгийг тус тус үр дүнтэй зохион байгуулсан.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтэнд 4090,8 сая төгрөг, аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 10619,4 сая төгрөг, аймгийн улс, орон нутгийн төсвийн 43 байгууллагын төсвийн хэрэгжилт, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг ханган төлбөр тооцоог гүйцэтгэж 1721 ш төлбөрийн хүсэлтээр 11285,1 сая төгрөгийн гүйлгээг хийсэн байна.

Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 11657,4 сая төгрөгийн санхүүжилт авч сарчилсан хуваарийн дагуу орон нутгийн төсөвт байгууллагуудад хуваарилан санхүүжүүлэв.

Тусгай зориулалтын шилжүүлгээр ерөнхий боловсролын сургууль 22840,4 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 9064,1 сая төгрөг, хүүхдийн хөдөлмөр хамгааллын үйлчилгээний тусгай шилжүүлэг 298,1 сая төгрөг, эрүүл мэндийн тусгай шилжүүлэг 5916,1 сая төгрөг, газрын, харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг 403,5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 4090,8 сая төгрөг санхүүжилт авч, хуваарийн дагуу аймаг, сумдын төсвийн байгууллагуудад хуваарилсан.

Татвар төлөлт:

Шинээр 1 хуулийн этгээд нэмж бүртгүүлж, 1314 хуулийн этгээд, 129 салбар газар 604 төрийн бус болон төсөвт байгууллага, 28189 иргэний бүртгэлтэй нийт 302232 бүртгэлтэй татвар төлөгчийн бааз суурьтай үйл ажиллагаа явуулж байна.

НӨАТ суутган төлөгч 293, онцгой албан татвар төлөгч 2 татвар төлөгчийн улирлын тайланг хүлээн авч, НӨАТУС, ХХОАТ, цахим татварын системийн өөрчлөлтийн талаар сургалт зохион байгуулж, 63 татвар төлөгч хамрагдсан.

Улсын төсөвт 150.6 сая төгрөг, аймгийн төсөвт 112.3 сая төгрөг сумын төсөвт 218.5 сая төгрөг, нийт 481.4 сая төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна.

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах, техникийн хяналтын үзлэг 11.9 сая төгрөгийн агаарын бохирдлын төлбөрт 0.8 сая, зам ашигласны төлбөрт 4.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэв.

Татварын цахим систем ebarimt-ийн тохиролд хонжвор хожсон 3 иргэний материалыг ТЕГ-т хүргүүлсэн. 12 иргэний газрын эрх шилжүүлэх гэрээний дагуу татвар ногдуулан ажилласан.

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангуудын төлөвлөгөө 1747.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 1782.5 сая төгрөг төвлөрүүлж, сангийн төлөвлөгөө 102 хувийн биелэлттэй байна.

Оны эхний 10 дугаар сарын байдлаар 932 ажил олгогчийн 13661 даатгуулагч шинээр албан журмын даатгал, 9367 даатгуулагч сайн дурын даатгалд тус тус хамрагдсан.

Аймгийн хэмжээнд нийт 3274 даатгуулагчдад тэтгэмжийн сангаас 2512,1 сая төгрөгийн тэтгэмж олгов. Үүнд: ХЧТА 1225 даатгуулагчдад 125,6 сая төгрөг, ЖА-1332 даатгуулагчдад 1521,8 сая төгрөг, оршуулга 458 даатгуулагчдад 458.0 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмж 259 даатгуулагчдад 406,7 сая төгрөг тус тус олгосон.

Архивын лавлагаа 401 гаргасан ба нийгмийн даатгалын шимтгэл төлсөн болон төтөлөөгүй тодорхойлолт, цалингийн лавлагаа 349, ажилласан жил нөхөн тооцох 50 хүн лавлагаа авч үйлчлүүлсэн.

ЭХМК-ын 5 удаагийн хурлаар нийт 258 хүний хөдөлмөрийн чадвараа алдалтын асуудлыг хэлэлцэн шинээр 38, цуцалсан 8, сунгасан 212 хүний хөдөлгөөнийг мэдээллийн баазад оруулсан.

Санхүүгийн хяналт, аудитын алба

Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд нийт 2681.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, дутуу олгосон ур чадвар, мэргэжлийн зэргийн нэмэгдэл 890,5 мянган төгрөгийг нөхөн олгох, илэрсэн зөрчлүүдийг арилгуулахаар улсын байцаагчийн 5 заалт бүхий албан шаардлага, 9 заалт бүхий зөвлөмж, Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийхэд анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой 66,0 мянган төгрөг, цалин хөлстэй холбоотой 646,0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 7 заалт бүхий зөвлөмж тус тус өгсөн.

Тус сумын Соёлын төвийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийхэд цалин хөлстэй холбоотой 65,8 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийхэд цалин хөлстэй холбоотой 3196,3 мянган төгрөг, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 3019,0 мянган төгрөг, анхан шатны баримт дутуу тайлагнасан 899,7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 3 заалт бүхий албан шаардлага, 5 заалт бүхий зөвлөмж өгсөн.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас аймгийн Засаг даргын Тамгын газрын болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын нийт 240 ажилтанд, иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид нийт 203 лавлагаа мэдээллийг өгч ажилласан.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 654, боловсон хүчний 36 захирамжийн төсөлд шийдвэр гаргах зөвшөөрлийн хуудсаар үйлчилгээ үзүүлж, баталгаажигдсан шийдвэрийг бүртгэлжүүлэн санд байршууллаа. Аймгийн Засаг даргаас 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 690 шийдвэр батлагдан гарсан бөгөөд үүнээс үйл ажиллагааны 654 шийдвэрийг аймгийн www.uvurkhangai.mn цахим сайтад байршуулан иргэдэд мэдээллийг шуурхай авах боломжийг ханган ажиллаж байна.

Хүний эрхийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх, төрийн байгууллага, төрийн албан тушаалтнуудын хүний эрхийн ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын ажлын хэсэгтэй хамтран хууль, хяналт, эрүүл мэнд, боловсрол, төрийн захиргааны зэрэг нийт 100 гаруй албан хаагчдад "Хүний эрхэд суурилсан хандлага" сэдэвт сургалтыг зохион байгуулав.

Иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, үнэ төлбөргүй зөвлөгөө мэдээлэл өгөх өдөрлөгийг Монголын хуульчдын холбооны төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх хороотой хамтран Арвайхээр суманд зохион байгуулж, нийт 50 гаруй иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.

Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Архидалтгүй-Өвөрхангай" шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр архины хамааралтай болон архинд донтох эмгэгтэй иргэдтэй ажиллах үүрэг бүхий аймгийн "Мэргэжлийн баг", сумдын "Аддиктологийн баг"-ийн үйл ажиллагааг таниулах, архины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй арга хэмжээ, санаачлага, сайн туршлагыг төрийн албан хаагч,

иргэдэд түгээн дэлгэрүүлэх, архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Яг одоо татгалзъя” уриатай нэгдсэн цахим аяныг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсгийн тус аймагт ажиллах хугацаанд 10 дугаар сарын 18-21-ны өдрүүдэд аймгийн төв Арвайхээр хотноо аймгий Засаг даргын дэргэдэх “Мэдээлэл шуурхай удирдлагын төв”-ийн иргэний танхимд тус аймгийн ИТХурлын ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Иргэн төв”-тэй соён гэгээрүүлэх өдөрлөгт 170 гаруй иргэд, ААНэгж байгууллага, төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулсан “Олон нийтийн хяналт ба шудрага ёс” сэдэвт уулзалтыг зохион байгуулав. Мөн тус аймгийн ХАСХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудын сургалтад сумдын Тамгын газрын дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, хэлтэс, газар, албадын ХАСХОМ хариуцсан нийт 56 эрх бүхий албан тушаалтныг, ХОМэдүүлэг гаргах 200 гаруй төрийн албан хаагчдыг идэвхитэй хамруулан, сургалт, хэлэлцүүлгийг тус тус үр дүнтэй зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газрын хэсгийн тавьсан шаардлагын хүрээнд холбогдох судалгааг гаргуулан хүргүүлэв. Аймгийн төрийн байгууллагуудын ёс зүйн ажилтны ажилтны судалгаа болон АТГ-ын 2017, 2018 оны зөвлөмжийн хэрэгжилт, АТҮХөтөлбөрийн хэрэгжилтийг тус тус гарган хүргүүлэв.

Аймгийн Архивын тасагт байгууллага, иргэдээс 1264 өргөдөл хүлээн авч 596 лавлагаа, 2314 хуулбар, 219 тодорхойлолт олгоод байна. “Архивын тоо бүртгэл, эрэл хайлтын программ”-д 951 хадгаламжийн нэгжийн 71865 хуудас, 37889 заалт, 367861 хүний нэр, 58416 байгууллагын нэр, 67905 газар зүйн нэр бүхий захирамжлалын баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн.

Мөн 684 хадгаламжийн нэгжийн 55133 хуудас баримтыг PDF холбож, 616 хадгаламжийн нэгжийн 45349 хуудас баримтыг Photoshop программд засварлаж оруулсан байна.

ЦАГДААГИЙН ГАЗАР

Цагдаагийн газарт энэ оны эхний 10 сард 3752 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь 853 буюу +22.7 хувиар өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй 766, зөрчлийн шинжтэй 2986 гомдол мэдээлэл бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 710 буюу 92.6 хувийг 5 хоногт, 48 буюу 6.7 хувийг 6-аас дээш хоногт, зөрчлийн шинжтэй гомдлын 2563 буюу 85.8 хувийг 3 хоногт, 423 буюу 14.2 хувийг 4-өөс дээш хоногт шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн 23 нь буюу 0.6 хувийг шийдвэрлээгүй буюу хуулийн хугацаанд шалгаж байна.

Аймгийн хэмжээнд 419 холбогдогчтой, 1.379.6 мянган төгрөгийн хохиролтой, 548 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 47 хэргээр буюу +9.3 хувиар өссөн, хэргийн илрүүлэлт 41.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс -0.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хэргийн төрлөөр авч үзвэл хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг гэмт хэрэг 15 бүртгэгдэж, 7 буюу +87.5 хувиар, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 28 бүртгэгдэж 17-оор буюу +2.5 дахин, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 293 бүртгэгдэж 58-аар буюу +24.7%, залилах гэмт хэрэг 5 бүртгэгдэж 10-аар -3 дахин, мал хулгайлах гэмт хэрэг 34 бүртгэгдэж 14 буюу +70.0 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 10 бүртгэгдэж, 8-аар буюу +5 дахин, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 28 бүртгэгдэж 11-ээр буюу +64.7 хувиар тус тус өсч, хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 149 бүртгэгдэж 31-ээр буюу -17.2 хувиар буурсан,

авто тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 25 бүртгэгдэж 18-аар буюу -41.8 %-иар буурч тус тус буурсан байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүд нь бүртгэгдсэн гэмт хэргийн дотор 85.7 хувийн эзэлж байна.

Аймгийн хэмжээнд өмчлөх эрхийн эсрэг 293 гэмт хэрэг бүртгэгдснээс иргэдийн өмчийг хулгайлах 166, малын хулгайлах гэмт хэрэг 51, тээврийн хэрэгсэл хулгайлах 19, дээрэмдэх 11, залилах 20 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан шалгасныг урьд оны мөн үетэй харьцуулахад 58 буюу +24.7 хувиар, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 28 бүртгэгдэж 11-ээр буюу +64.7 хувиар тус тус өссөн байна.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 149 бүртгэгдэж 31-өөр буюу -17.2 хувиар буурсан, Авто тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 25 бүртгэгдэж 18-аар буюу -72.0 %-иар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргийн дийлэнх хувийг цонх хагалах, хөших, цонхоор орох, гэр, орон сууцны хаалга, цоожийг нь эвдэж орох, малын хулгайн гэмт хэрэг нь иргэдийн хараа хяналт сонор, сэрэмж сул, малаа байнга хариулага маллагаагүй орхидог, цахимаар иргэдийг хууран мэхэлж, итгэл эвдэх байдлыг ашиглан үйлдэгдэж байна.

Нийт бүртгэгдсэн 548 гэмт хэргээс 188 буюу 34.3 хувийг согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байна. Зөрчил өмнөх оноос 34499 буюу +83.7 хувиар өссөн байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажын үр дүн, олон нийтийн эргүүл, байнгын пост, цагийн менежменттэй постуудыг ажиллуулснаар тодорхой үр дүнд хүрч байгаагаар тодорхойлогдож байна. Нийт бүртгэгдсэн 34499 зөрчлөөс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1756 зөрчил байгаа нь өмнөх оны мөн үеэс 309-оор буюу +21.3 хувиар өссөн байна.

ДӨРӨВ. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Тус байгууллагаас 2019-2020 онд төсвийн санхүүжилтээр үндсэн нарийн мэргэжлийн эмчээр суралцах шалгалтанд тэнцсэн 14 их эмчтэй гэрээ байгуулж, 5 их эмч байгууллагын зардлаар тус тус шийдвэрлэсэн.

“Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөх бодлогын баримт бичгүүд”, “Харилцаа эзэмших ур чадвар” сэдэвт сургалт зохион байгуулахад БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн шинэ төгсөгч 60 гаруй эмч мэргэжилтнүүд хамрагдсан.

“Томуугийн вакцины аймгийн хэмжээнд зохион байгуулах тухай” байгууллагын даргын тушаалаар тархвар судлал, сайн дурын вакцинд 3950 хүн хамруулахаас 93 хувийн хамралттай байна. Томуугийн тандалтын төврүү тандалтын мэдээг 7 хоноогоор 4 удаа нэгтгэн 23716 амбулаторийн үзлэгт хамрагдаж, ТТӨ-1001, алсын дуудлага- 1029, ТТӨ-74, АЗХХ-97 тус тус мэдээлсэн.

Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, “Тэмбүүг устгая” үйл ажиллагааны хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах удирдамжийг боловсруулан БОЭТ, сум өрхийн эмнэлэг эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлэн ажиллаж байна. Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, “Тэмбүүг устгая” үйл ажиллагааны хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга, БЗДХ-ын асуудал хариуцсан эмч, хувийн хэвшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулан ажиллалаа. БОЭТ,

сум, өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдээс тэмбүүгийн үзлэг шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоог авч нэгтгэн ХӨСҮТ-д мэдээлсэн.

Эмгэг судлалын үндэсний төвтэй хамтран “Умайн хүзүүний эсийн шинжилгээний ажлын байрны давтан сургалт”-ыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмгэг судлаач, эс судлаач эмч, хавдарын бүртгэл мэдээллийн ажилтан, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нийт 30 мэргэжилтнийг хамруулан зохион байгууллаа.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГ

Олон улсын багш нарын 25 дахь өдөр, Монголын багш нарын 53 дахь өдрийн баярын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэв.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын амжилтыг үнэлэх, урамшуулал олгох журам”-ын хүрээнд 2018-2019 оны хичээлийн жилд амжилттай ажилласан, журмын шалгуурыг хангасан шилдэг 29 багшийг тус бүр 2 сая, нийт 58 сая төгрөгөөр урамшууллаа.

БСУГазраас Арвайхээр сумын цэцэрлэг, ерөнхий боловсролын 4 сургууль, лаборатори Мэргэд сургуулийн үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгууллаа.

Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын харъяат нэрт хөөмийч С.Зулсарын нэрэмжит Хөөмийн уралдааныг Монголын Хөөмийн холбоотой хамтран зохион байгуулж, Улаанбаатар хот, Өвөрхангай, Баянхонгор, Увс, Говь-Алтай, Говьсүмбэр, Төв, Ховд, Хөвсгөл аймгийн 30 гаруй хөөмийч, БНХАУ-ын ӨМӨЗО-ны 4 хөөмийч оролцов.

БСШУС-ын сайдын 2019 оны А/355 дугаар тушаалаар Улсын тэргүүний цэцэрлэгээр Өвөрхангай аймгийн Баянгол сумын цэцэрлэг шалгарлаа.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Бага ангийн сурагчдын унших чадварыг үнэлэх, сайжруулах” сургалтад 1 мэргэжилтэн хамрагдаж, тус сургалтыг бага ангийн багш нарт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Баянхонгор аймгийн Шаргалжуут тосгонд зохион байгуулагдсан “Салбарын албан хаагчдыг чадавхжуулах бүсийн сургалт”-ад газрын 13 албан хаагч, хамтарсан багийн сургагч багш бэлтгэх сургалтад холбогдох мэргэжилтнүүд тус тус хамрагдав.

Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хамтарсан тушаалаар батлагдсан “Нийгмийн хамгааллын мэргэжлийн анги” нь улсын Онцгой байдлын газраас томилогдсон ажлын хэсгээс бэлэн байдлыг шалгах үйл ажиллагаанд хувцас, аранзны бүрдлийг ханган оролцож, жагсаалын бэлтгэл шалгуулсан.

“Хүүхдэд ээлтэй аймаг” санаачлагын хүрээнд 14 сумын 1001 хүүхдээс хүүхдэд ээлтэй аюулгүй орчиныг үнэлэх санал асуулгыг авч, нэгтгэн дүгнэж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй үйл ажиллагааг эрчимжүүлэх, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хүүхдийн төлөө зөвлөл, Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөл, Хамтарсан баг, Хүүхдийн элч, аж ахуйн нэгж байгууллагын дэргэдэх Гэр бүлийн зөвлөлийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хэлэлцэж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хүрээнд хэрэгжилтийг хангах хууль тогтоомжийг сурталчилан таниулах зорилгоор Арвайхээр суманд ажлын хэсэг ажиллаж, хүүхэд хамгааллын

хариу үйлчилгээ үзүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх удирдамжийн дагуу ажиллаж, дараах үйлчилгээг үзүүлсэн байна.

Гэр бүлийн туршилтын хөтөлбөрийн хүрээнд Арвайхээр сумын хэмжээнд сонгогдсон 154 өрхөөс 13 багийн 39 өрхөд нөхцөл байдлын үнэлгээг хийж, өрхийн төлөвлөгөө боловсруулан ажилласан.

Өмгөөлөгчдийн холбооны салбар Өвөрхангай аймаг дахь өмгөөлөгчдийн зөвлөлтэй байгууллагын хамтран ажиллах гэрээ болон насанд хүрээгүй бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээг байгуулан ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1 эмэгтэйг 2 хүүхдийн хамт “Хүүхэд, эмэгтэйчүүдийг түр хамгаалах байр”-анд хүлээн авч, нийгмийн нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Олон Улсын Охидын өдрийг угтан “Өнгө нэмье” охидын өдрийг зохион байгуулах тухай удирдамж, тоотыг боловсруулан 19 суманд хүргүүлж, сумдаас ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн. Тус өдрийг угтан Арвайхээр сумын ЕБ-ын 4 дүгээр сургуулийн 50 охиныг, ээжийн хамт урьж оролцуулан “Хамтдаа хамгаалъя” өдөрлөгийг аймаг дахь Монголын Эмэгтэйчүүдийн холбооны салбар зөвлөлтэй хамтран зохион байгууллаа.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны 3-р улирлын хурлыг зохион байгуулж, ХЭХЗХ-оор үйлчлүүлж буй бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидын мэдээлэл болон мөрдөн байцаалт, шүүхийн шатанд хэрхэн ажиллаж байгааг талаарх мэдээллийг танилцуулж, хохирогч 1 хүүхдийг Үжин төвд шилжүүлэн, хүргэж өгөхөөр шийдвэрлэв,

Өрх бүрд өсвөрийн байгаль хамгаалагч бэлтгэх, хүүхэд багачуудад байгаль орчныг хамгаалах талаар мэдлэг мэдээлэл олгох, бага наснаас нь байгаль орчинтой зөв харьцах дадал хэвшүүлэх зорилгоор “Хандлагаа өөрчилъе” уриан дор “Ногоон паспорт” эзэмшигч хүүхдүүдийн чуулга уулзалтыг аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газартай хамтран зохион байгуулж, 19 сумын 200 гаруй сурагч оролцов.

“Залуусын хүч” залуучуудын хөгжлийг дэмжих сарын аяны хүрээнд аймгийн “Соёмбо” мэдээллийн агентлаг болон “Арцат” худалдааны төвтэй хамтран “Би халамжтай аав” телевизийн ток шоууг залуу гэр бүлийн төлөөллийг оролцуулж, амжилттай зохион байгуулж цахим орчинд сурталчиллаа.

Уламжлал болгон зохион байгуулдаг “Нэг сайн үйлс-Нэг сайн өрх” уриатай “1000 төгрөг-1000 залуу” сайн үйлсийн аяныг 2019 оны 09 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн өрнүүлж байна. Тус аяны хүрээнд “Хамгийн залуу-Хамгийн олон хүүхэдтэй” гэр бүлийг сонгон нийгмийн асуудлыг нь шийдвэрлэдэ бөгөөд энэ жил аймгийн хэмжээнд “Хамгийн олон хүүхэдтэй – Хамгийн залуу” гэр бүлийг сонгон ажиллахаар залуучуудын хөгжлийн төвөөс зохион байгуулж байгаа үйл ажиллагаа бүр дээр хандивын аяныг өрнүүлж байна.

“Залуусын хүч” сарын аяны хаалтын үйл ажиллагааг зохион байгуулж, 60 гаруй аж ахуйн нэгж албан байгууллагын төлөөлөл залуучуудыг хамрууллаа.

Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас санаачлан 21 аймаг, үндэсний хэмжээнд өрнүүлж буй Нийгмийн ардчилал Монголын Оюутны холбооноос хэрэгжүүлж буй “Ирээдүйн эзэд 2019” аяны арга хэмжээнд Арвайхээр сумын ЕБ-ын 5 сургуулийн 250 гаруй төгсөх ангийн сурагчид болон Политехникийн коллежийн 200 орчим оюутнуудыг хамрууллаа.

БИЕИЙН ТАМИР, СПОРТ

Монгол Улсын Их Хурлын гишүүн, гавьяат хуульч Д.Лүндээжанцангийн нэрэмжит Хангайн болон говийн бүсийн аймгуудын өсвөрийн шатарчдын “Багийн аварга” шалгаруулах тэмцээн Арвайхээр суманд зохион байгуулж, бүсээс шалгарсан эрэгтэй, эмэгтэй 7 насны ангиллаар 11 багийн 160 гаруй тамирчид оролцсон. Мөн Олон Улсын хэмжээний мастер Д.Амарсанаагийн нэрэмжит өсвөр үеийн хөнгөн атлетикийн намрын тэргүүн шалгаруулах тэмцээнд 12 багийн 110 тамирчин оролцсон.

Монгол улсын хүчит арслан Г. Цоодолийн нэрэмжит өсвөр үеийн үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах барилдааныг Гучин-Ус суманд аймгаас төрөн гарсан алдар цуутай бөхчүүдийн залгамж халааг бэлтгэх, монгол бөхийн өв соёлыг хүүхэд, багачуудад сурталчлан таниулах, 2019 оны Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдыг сонгон шалгаруулах зорилготойгоор зохион байгуулж, 13 сумын 80 бөх 16, 17, 18 насны ангиллуудад хүч сорин барилдаж насныхаа ангилал тус бүр эхний 8 байр, багийн дүнгээр эхний 3 байр мөн уран баридаанчийг шалгаруулсан..

Өвөрхангай аймгийн талбайн хөлбөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг Хархорин суманд зохион байгуулж, нийт 24 багийн 360 тамирчин 5 насны ангиллаар оролцсон.

Казакстаны Алматы хотод зохион байгуулагдсан Дэлхий аварга шалгаруулах тэмцээнд Хангай жудо клубын 3 тамирчин тус бүр шанагалт 7-р байрт шалгарсан.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан БНСУ-ын элчин сайдын нэрэмжит Таеквондогийн цомын тэмцээнд 30 байгууллагын 500 тамирчид 1 дасгалжуулагчтай 16 тамирчин оролцож 5 мөнгө, 5 хүрэл, 7 алт, медаль тус тус хүртэж багийн дүнгээр 3-р байр эзэллээ.

Үндэсний бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах 65 дахь удаагийн тэмцээн Дундговь аймагт зохион байгуулагдан, нийт 90 бөх өрсөлдөж 1 бөх шагналт 9-р байрт шалгарч, мөн Уран гараа дэвээ бөхийн шагналыг Хархорин сумын бөх хүртлээ.

Софт волейболын улсын аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж 52 багийн 360 тамирчин 4 насны ангиллаар өрсөлдөж, 1 дасгалжуулагчтай 7 багийн 42 тамирчин оролцож, 55-64 насны ангилалд алт, 35-45 насны ангилалд мөнгөн медаль тус тус хүртэж багийн дүнгээр тэргүүн байр эзэллээ.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системд байнгын 731, улирлын 115, түр 213 шинэ ажлын байр бий болсныг бүртгэж мэдээллээ. Нийт шинэ ажлын байрыг эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 10.9% боловсруулах үйлдвэрлэлд 26.1%, бөөний худалдаа 10.1%, боловсролын салбарт 24.3%, уул уурхайд 1%, барилга 7.5%, бусад салбарт 20.1% тус тус байна.

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системд бүртгэлтэй 690 ажил хайгч иргэний мэдээллийг шинэчлэн, идэвхижүүлж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд ганцаарчилсан зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээнд 513 иргэнийг, бүлгийн зөвлөгөө мэдээлэлд 862 иргэнийг хамруулж, хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системд бүртгэлээ.

Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагаас 731 ажлын байрны захиалга хүлээн авч 719 иргэнийг ажлын байранд зуучиллаа.

Ажилгүйдлийн даатгалын тэтгэмжид хамрагдах 37 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн нэгдсэн санд ажил хайгчаар бүртгэн Нийгмийн даатгалын хэлтэст шилжүүллээ.

“Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас Арвайхээр сумын ажил эрхэлдэггүй болон хүүхэд, өндөр настан асардаг эмэгтэйчүүдэд зориулсан өдөрлөг зохион байгуулж нийт 13 багийн 80 эмэгтэй оролцож, гарын авлагаар хангалаа.

“Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээг Арвайхээр суманд зохион байгуулсан. Уг арга хэмжээний хүрээнд хувийн хэвшлийн томоохон 3 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, ажилчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн.

“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхүүдийн “Залуу малчдын туршлага солилцох уулзалт, зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, уг арга хэмжээнд оролцсон 90 малчинд хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн ахюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгч, гарын авлагаар хангалаа.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 1 иргэнийг ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд хамруулж, 360.0 мянган төгрөгийн санхүүжилт зарцуулсан.

“Залуучуудын хөдөлмөр, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт”-т хамрагдсан 1 иргэнийг ажлын байрны түрээсийн хөнгөлөлтөд хамруулж, 600.0 мянган төгрөгийн санхүүжилт зарцуулсан.

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн мэргэжлийн сургалтыг Өвөрхангай аймаг дахь Политехникийн коллежтой хамтран “Хоол үйлдвэрлэл, тогооч”, “Талх, нарийн боов үйлдвэрлэл”-ийн мэргэжлээр Хархорин суманд 40 иргэнийг хамруулж, 6.4 сая төгрөгийн санхүүжилт зарцууллаа.

Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хатран зохион байгуулж буй “Хүүхэд хамгаалагч” төсөлд хамрагдаж буй 2 ахмад мэргэжилтэнд 10 дугаар сарын урамшуулал 560.000 төгрөгийн санхүүжилт олголоо.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд малжуулах арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй 17 сумын 64 малчин өрхийг малжуулах арга хэмжээд хамруулж, 5917 толгой бог малыг зах зээлийн дундаж ханшаар худалдан авч өгөх ажлыг зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 287,0 сая төгрөгийг зарцуулсан.

“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхүүдийн “Залуу малчдын туршлага солилцох уулзалт, зөвлөгөөн”-ийг зөвлөгөөнийг 2019 оны 10 дугаар сарын 10-11 өдрүүдэд Арвайхээр суманд амжилттай зохион байгууллаа. Дээрх арга хэмжээнд 17 сумын 90 малчин оролцсон.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн зохион байгуулалттайгаар ажлын байрыг дэмжих арга хэмжээнд 3 сумын 15 иргэнийг хамрагдаж, байнгын ажлын байртай болсон.

Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 14 сумын 120 иргэн хамрагдаж, нийт 12 га газарт төмс хүнсний ногооны тариалалт хийж, нийт 30 тонн ургац хураан авч зах зээлд борлуулсан байна.

Улс, орон нутгийн төсвөөс халамжийн тэтгэвэрт 2281.6 тэрбум төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1498.9 тэрбум төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 926.7 сая төгрөг, ахмад настаны нийгмийн халамжийн үйлчилгээнд 964.3 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмжид 226.4 сая төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 378.2 сая төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 1223.9 тэрбум төгрөг, банкны шимтгэл, амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшууллын зардалд 21.6 сая төгрөгийг зарцууллаа.

Алдар цолтон ахмад настануудын тэтгэмжид 56.0 сая, алдарт эхийн тэтгэмжид 1358.9 тэрбум, насны хишгийн зардалд 920.0 сая, өрх толгойлсон эх эцгийн тэтгэмжид 274.6 сая, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 39.7 сая, цалинтай ээж хөтөлбөрт 2524.6 тэрбум төгрөг, нийт 12735.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авч нийгмийн халамжийн тэтгэвэрт 1521 иргэнд 2203.4 тэрбум төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжид 2362 иргэнд 1487.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна. Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 2146 иргэнд 959.2 сая төгрөг, ахмад настаны нийгмийн халамжийн үйлчилгээнд 7490 иргэнд 899.5 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмжид 475 иргэнд 183.4 сая төгрөг, жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжид 2108 иргэнд 360.4 сая төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 13187 иргэнд 1096.6 тэрбум төгрөг, алдар цолтон ахмад настануудын тэтгэмжид 38 иргэнд 54.9 сая төгрөг, алдарт эхийн тэтгэмжид 10187 иргэнд 1353.2 тэрбум төгрөг, насны хишгийн зардалд 5523 иргэнд 890.4 сая төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт 6899 иргэнд 2529.0 тэрбум төгрөг, өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид 288 иргэнд 259.0 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 145 иргэнд 3.8 сая төгрөг, амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшууллын зардалд 11.3 сая төгрөг, банкны шимтгэлд 5.5 сая төгрөг нийт давхардсан тоогоор 52319 иргэнд 12298.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр тэтгэмжийг олгосон байна.

Нийгмийн халамжийн салбарын албан хаагчдыг мэргэшүүлэх, нийгмийн ажилтны мэргэжлийн мэдлэг, ур чадвар олгох, халамжийн шинэчлэлийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, хандлага төлөвшүүлэх хангайн бүсийн сургалт Өвөрхангай аймагт зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус сургалтад Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн нийгмийн халамжийн асуудал хариуцсан 131 төрийн албан хаагч хамрагдсан бөгөөд тус сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас Азийн хөгжлийн банкны “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт” төслийн санхүүжилтээр зохион байгууллаа.

Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт Арвайхээр сумаас хамрагдаж буй тогоочийн сургалтанд хамрагдах хүсэлтэй 5 иргэнийг Өвөрхангай аймгийн “Политехникийн коллежи”-д тогоочийн мэргэжил олгох сургалтанд хамрууллаа. Мөн тус хөтөлбөрт Арвайхээр сумаас хамрагдаж буй 145 өрхөөс ажил хайгчаар бүртгүүлэх хүсэлтэй 125 иргэний мэдээллийг бүртгэж ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2 удаагийн хуралдаан зохион байгуулж, 20 хүүхдийн асуудлыг хэлэлцсэн байна. Үүнээс 5 хүүхдэд байнгын асаргааг шинээр тогтоож, 9 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, 1 хүүхдийн байнгын асаргааг цуцалж, 1 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлж, 10 хүүхэд нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ДЭД БҮТЦИЙН САЛБАР ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх сургалтыг 19 сумын мал зүйч нарт зохион байгуулан малын генетик нөөцийн төлөв байдлын тайланг хүлээн авч нэгтгэж байна.

Аймгийн Онцгой байдлын газар, зооноз судлал, мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран Бүрд, Өлзийт сумдад үлийн цагаан огтоно устгах ажлыг тухайн сумдын онцгой байдлын штабтай хамтран ажилгүй иргэд, төрийн албан хаагчдыг дайчлан механик аргаар огтоно устгалын ажлыг хийж гүйцэтгэлээ.

“Үхэр” сүрэг аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан ИТХ-ын тэргүүлэгчдээр батлуулж 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлэхээр боллоо.

2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажил шалгаж хүлээн авах ажлын удирдамж боловсруулан 9 ажлын хэсэг сумдад ажиллаж байна.

Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/119 дүгээр тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын хүрээнд Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/41 дүгээр тушаалаар тус аймагт 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эрх олгогдсоны дагуу төсөл сонгон шалгаруулах дэд хорооноос эхний ээлжинд эрэмбэлэгдсэн 22 төслийн 15 төсөл нь зээлээ авч 7 төсөл банкны шалгуур хангаагүйн улмаас буцаагдсан тул дараагийн ээлжинд эрэмбэлэгдэж банкинд судлуулахаар хүлээгдэж байгаа төслүүдийн жагсаалтыг арилжааны банкуудад хүргүүллээ.

“Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүллээ.

Ахуй үйлчилгээг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд сумдад үйл ажиллагаа явуулж байгаа халуун усны дэлгэрэнгүй судлагааг хийж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.5 дахь заалтад “Хархорин суманд гурил тэжээлийн үйлдвэрийг орчин үеийн техник технологид суурилан бий болгох” зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Хархорин “Буудайн шим” ХХК-ны ашиглаж байсан гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмжийг ХХААХҮЯамны харьяа ТЭДСанд төлөх өр төлбөрт тооцон аймгийн ажлын хэсэг хамтран ТЭДСангийн Хархорин салбарт 2019 оны 10 сарын 10 нд хүлээлцлээ.

“Атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 60 жил”-ийн ой угтсан бүтээлч ажлын хүрээнд газар тариалангийн салбарын түүхэн дурсамж, ном хэвлүүлэхээр бэлтгэж байна.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

“Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилт жил”-ийн хүрээнд Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор намрын бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгууллаа. Үүнтэй холбогдуулан нийтийн эзэмшлийн талбай, амьдардаг орчиндоо мод бут тарих, ногоон байгууламжид үзлэг тооллого хийх, тарьсан мод бутыг өвөлжүүлэх бэлтгэлийг хангах, намрын цэнэг усалгаа хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.

Намрын мод тарих өдрийн арга хэмжээнд аймгийн хэмжээгээр нийт 102 аж ахуйн нэгж, байгууллага, 1890 иргэн оролцож 800 ширхэг мод, 1900 ширхэг бут сөөг буюу нийт 2700 ширхэг мод бут тарьсан байна.

Арвайхээр хотын Дэлгэрэх голын дагуу шинээр байгуулсан “Хунбоусу” цэцэрлэгт хүрээлэн, БОАЖЯамны дэмжлэгтэйгээр байгуулагдсан “Ногоон паспорт – Ногоон төгөл” модлог ургамлын цуглуулга бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн зэрэг ногоон байгууламжуудад хаврын тарилтаар тарьсан мод бутыг арчлах, намрын цэнэг усалгаа хийх ажилд аймгийн төвийн 50 гаруй байгууллага аж ахуйн нэгжийн 450 гаруй ажилтан, албан хаагчид оролцлоо.

БОАЖЯамны Ой судалгаа хөгжлийн төвөөс аймгийн ой бүхий газруудаар ойн хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох, тэмцлийн ажил явуулах талбай сонгох, дараа жилийн тархалтын урьдчилсан мэдээлэл боловсруулах зорилгоор намрын

судалгааны ажлыг нийт 78.5 мянган га талбайд явуулж ажлын гүйцэтгэлийн актыг сумдад хүлээлгэж өгсөн. Судалгаагаар Хархорин сумын Нарийн, Урт, Мойлт, Их бага Арцат, Баянгол зэрэг газруудаар ойн хөнөөлт шавж Өрөөсгөл хүр эрвээхэй, Сибирийн хүр эрвээхэйн тархалттай талбай байгааг тогтоосон.

“Ойн ашиглалтад тавих хяналтыг эрчимжүүлэх тухай” БОАЖЯамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 03/728 дугаар албан бичгээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулах, өвлийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд сум, нөхөрлөл, аж ахуйн нэгжүүдийн ойгоос мод түлээ бэлтгэх ажлын явц, Сум дундын Ой анги, байгаль хамгаалагчдын үйл ажиллагаатай танилцах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгаа хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, сумдад Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлсэн ажилд хяналт үнэлгээ хийх зорилгоор БОАЖГазар, МХГазрын хамтарсан ажлын хэсэг Хужирт, Бат-Өлзий сумдад 2019.09.05-07-ний өдрүүдэд ажиллаж хяналт шалгалт хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.

Өрх бүрт өсвөрийн байгаль хамгаалагч бэлтгэх, хүүхэд багачуудад байгаль орчныг хамгаалах талаар мэдлэг мэдээлэл олгох, бага наснаас нь байгаль орчинтой зөв харьцах дадал хэвшүүлэх зорилгоор “Хандлагаа өөрчилье” уриан дор “Ногоон паспорт” эзэмшигч хүүхдүүдийн чуулга уулзалтыг 2019 оны 10 сарын 02 -ны өдөр Арвайхээр хотын Хүүхдийн ордонд зохион байгуулж 19 сумын 200 төлөөлөгч хүүхдүүд оролцлоо. Чуулганд оролцогч хүүхдүүд Модлог ургамлын цэцэрлэгт хүрээлэнд 60 ширхэг мод тарьялаа.

“Хоггүй цэвэрхэн Монгол” аяны хүрээнд Арвайхээр хотын захирагчийн алба, Арвайхээр тохижилт үйлчилгээ орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, ЕБ-ын сургуулиуд хамтран Дайргын гол орчмын 2км талбайн хог хаягдлыг цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулж нийт 32 тн хог хаягдлыг хогийн төвлөрсөн цэгт хүргэсэн. Мөн Онги-Таац голын сав газрын захиргаа Зэвсэгт хүчний 256-р ангитай хамтран Онги гол орчмын 5 км газрыг цэвэрлэж ний 12 тн хог хог хаягдлыг хогийн төвлөрсөн цэгт нийлүүлсэн.

Арвайхээр сумын хөрсний бохирдлын судалгааны ажлыг гүйцэтгэх “Санлотус” ХХК-ний менежер Ү.Бум-Эрдэнэ, захирал, доктор Н.Үржинбадам нартай хамтарч Арвайхээр суманд 10 цэгээс хөрсний дээж авах, тандалт судалгааны ажлыг хамтран гүйцэтгэсэн.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдан Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Хайрхандулаан сумдын нутагт бичил уурхайн нөхөрлөлүүд болон газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн ажилд хяналт шалгалт хийж, нөхөн сэргээлт хүлээн авч ажиллалаа.

Ажлын хэсэг Гучин-Ус сумын нутагт 2018 онд газрын тосны хайгуулын тулгуур цооног өрөмдсөн ажлын түр суурин байрласан газар болон цооног өрөмдсөн газарт биологийн нөхөн сэргээлт хийсэн ажилтай танилцлаа. Тус хайгуулын талбайн биологийн нөхөн сэргээлтийн ажлыг эрх бүхий байгууллага болох “Эко Минерал” ХХК өдрийн хооронд нийт 3.56 га газрыг хамарсан биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 6 техник хэрэгсэл, 11 ажилтны бүрэлдэхүүнтэй холбогдох аргачлал, стандартын дагуу гүйцэтгэсэн байна. Аймгийн ИТХурлын 2018 оны 07/01 дугаар тогтоолоор Хайрхандулаан, Баруунбаян-Улаан сумдын нутаг дэвсгэрт 46 га талбайг бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авч, Ашигт малтмал, газрын тосны газраар дүгнэлт гаргуулсан бөгөөд дээрх газруудад сумын Засаг дарга 15 бичил эрхлэгчтэй гэрээ байгуулан 100 иргэнийг ажиллуулсан байна. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хайгуул, олборлолтын үйл

ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр үнг хүлээн авах журам”, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А-419 дугаар тушаалын дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авсан тухай акт үйлдсэн.

Монгол улсад аялал жуулчлалын салбар үүсч хөгжсөний 65 жилийн ой, Дэлхийн аялал жуулчлалын өдрийг угтаж дараах ажлуудыг зохион байгууллаа. Арвайхээр сумын ерөнхий боловсролын 4 сургуулийн Эко клубын 60 сурагчыг өндөр гэгээн Занабазарын нэрэмжит түүхэн музейг үзүүлсэн. Мөн аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн хэлэлцүүлгийг Хархорин суманд зохион байгуулж төр болон хувийн хэвшил, нөхөрлөл, морины хөтөч нийт 76 хүн оролцлоо.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хашиж хамгаалсан булгуудыг газар дээр нь үзэж, орон нутагт хүлээлгэн өгч, Өлзийт сумын Бөөрийн адаг булаг, Есөнзүйл сумын Холбоогийн дунд булаг, Овоотын булаг, Баянгол сумын Цайдмын булаг, Хөөврийн булаг, Богд сумын Сайн сүүжийн рашаан, Сахилдагтайн булаг, Олстойн булгуудыг хашиж хамгаалсан гүйцэтгэлийг хүлээн авч, цаашид хариуцан хамгаалах талаар иргэнтэй гэрээ байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар заавар зөвлөгөө өглөө.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Аймгийн Засаг даргын А/626 дугаар захирамжаар “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүй газар өмчлөх хүсэлт гаргасан 35 иргэнд 2.87 га газрыг өмчлүүлэв.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/619 дүгээр захирамжаар Арвайхээр сумын 13 дугаар баг “Дөл хороолол”-д газар эзэмших эрх авсан 7 иргэнд 0.33 га газрыг эзэмшүүлсэн.

Тарагт, Төгрөг, Хархорин сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж буй “Газар дэлхий” ХХК-тай хамтран ажиллаж, холбогдох мэдээ, мэдээлэл, судалгааг гарган өгч, Тарагт сумын багийн Иргэдийн нийтийн хурлуудад оролцож төлөвлөгөөний ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг иргэдэд таниулан, санал хүсэлтийг хүлээн авсан.

Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалахыг хүссэн 15 иргэний хүсэлтийг хүлээн авч, Газрын цахим биржид бүртгэн барьцаалагч банк болон банк бус санхүүгийн байгууллагад албан тоот хүргүүлж улсын тэмдэгтийн хураамж 150.000 төгрөгийг орон нутгийн төсөвт оруулав.

Арвайхээр суманд баригдаж буй 320 хүүхдийн сургууль, 50 ортой хүүхдийн эмнэлэг, 150 хүүхдийн цэцэрлэг, 2-р цэцэрлэгийн өргөтгөл, Мэргэжлийн хяналтын газрын барилга, Усан спортын барилга, Хүүхэд хамгааллын барилга, Хархорин сумын Соёлын төвийн барилга, Үерийн далангийн ажил, Хужирт сумын сургуулийн засварын ажил, 75 хүүхдийн цэцэрлэг, Баянгол сумын ЕБСургуулийн гал тогооны барилгын угсралтын ажил, бохир усны шугам сүлжээ, насос станцын угсралтын ажил, Арвайхээр сумын цэвэрлэх байгууламжийн үерийн ус зайлуулах сувгийн ажилд техникийн хяналт хийв.

Хужирт сумын Хөл бөмбөгийн талбай, Хархорин сумын 2 сургуулийн хөл бөмбөгийн талбай, 2-р цэцэрлэгийн өргөтгөл, Өлзийт сумын Спорт залны барилгад барилга байгууламжийг хүлээн авах комисс зохион байгуулж ажиллуулан ашиглалтанд оруулав.

Баянгол сумын ЕБСургуулийн гал тогооны барилгын угсралтын ажил, Бохир усны шугам сүлжээ, насос станцын угсралтын ажил, Арвайхээр сумын цэвэрлэх байгууламжийн үерийн ус зайлуулах сувгийн ажилд L3388-MON, Зүүн өмнөд

говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэгжтэй, Цагдаагийн газрын барилгад ЦЕГазартай тус тус техник хяналтын гэрээг байгуулж баталгаажуулан хяналтын тайланг гарган холбогдох газруудад хүргүүлэв.

10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төслийн багийнханд дулааны ачаалын хуваарилалтын тооцоо, хэрэглээний халуун усны ачааллын тооцоо, Арвайхээр сумын дулааны 2 дугаар хэлхээний шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэх төлөвлөгөөг гарган хүргүүлсэн.

Гучин-Ус сумын Соёлын төв, Хужирт суманд баригдаж байгаа 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын нэмэлт гэрээгээр хийгдэх ажлын төсвийг хянаж, ХОХБТХэлтэстэй хамтарсан хурлаар хэлэлцүүлэв.

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР

Ийлдэс судлалыг лабораторид хээлтүүлэгч малын бруцеллэз өвчний тандалтд шинжилгээнд 19 сумын 4500 дээж РБУ шинжилгээ хийхэд 108 дээж эерэг урвал үзүүлсэн.

Паразит судлалын лабораторид нийт 14 сумын 248 дээж шинжилснээс Хужирт, Хайрхан-дулаан, Богд сумдаас Стронгилиодоз Хайрхандулаан, Арвайхээр сумаас Нематодериоз Арвайхээр сумаас эймериоз илэрсэн.

Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж байгаа “ДЭЛХИЙН ХҮНС” махны үйлдвэрт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, махнаас дээж авч, аймгийн МЭЛабораторид шинжилгээнд хамруулсан.

Швейцарын хөгжлийн агентлагийн ногоон алт, малын эрүүл мэнд төсөлтөй хамтран 19 сумын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн нэгжийн эмч, малчдыг хамруулан малын эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх сугалтыг зохион байгуулсан. Уг сургалтанд нийт 324 хүн хамрагдсан.

УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Энэ сард агаарын дундаж температур -1.1 градус хүйтнээс 3,9 градус дулаан, нийт нутгаар шөнөдөө 4-6 градус хүйтэн, өдөртөө 6-11 градус дулаан байлаа. Энэ сарын агаарын дундаж температурыг олон жилийн дундажтай харьцуулж үзвэл Бүрд, Гучин-Ус, Зүйл, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Уянга, Хайрхандулаан сумдын нутгаар 0,1-1,4 градус дулаан, бусад сумдын нутгаар 0,3-1,8 градус хүйтэн байсан байна. Нийт нутгаар салхи секундэд 5-10 м/сек, Арвайхээр, Баян-Өндөр, Баруунбаян-Улаан, Төгрөг, Богд, Хужирт, Өлзийт, Сант, Гучин-Ус, Хархорин, Баянгол, Бүрд, Зүүнбаян-Улаан сумдын нутгаар 12-19 м/сек хүрч салхилсан байна. Энэ сард Хужирт, Баян-Өндөр, Хархорин, Бат-Өлзий, Бүрд, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Уянга сумдын нутгаар 2,2-8,7 мм, Арвайхээр, Баруунбаян-Улаан, Төгрөг, Богд, Баянгол, Сант, Хайрхандулаан сумдын нутгаар 0-0,8 мм тунадас орсон, бусад сумдын нутгаар тунадасгүй байлаа.

СУМДЫН МЭДЭЭЛЭЛ

Баян-Өндөр суманд нийт нутгаар зуншлага муу байснаас малчид оторт ихээр нүүж байна. Сумын Засаг дарга отрын бүсийн зөвлөгөөнд 2 удаа оролцож, малчдын отор нүүдлийн талаарх асуудлыг хэлэлцлээ. Отрын бүс болон бусад аймаг сумдаас малчдыг хүлээн авах боломжгүй гэсэн хэдий ч малчид Булган аймгийн Дашинчилэн, Баяннуур Төв аймгийн Угтаал зэрэг сумд руу ихээр нүүж байна.

Баянгол суманд эрүүл мэндийн төвийн амбулаториор 223 иргэн үйлчлүүлж, 38 иргэн хэвтэн эмчлүүлэн, алсын болон төвийн дуудлагаар 52 иргэнд эмнэлгийн үйлчилгээг шуурхай хүргээд байна.

